



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 14



## Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 57.7 (61.8%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2022 оны эхний улиралд 151.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.7 (61.8%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардал 617.9 тэрбум төгрөг болж, 430.5 (3.3 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2021 I-III	2022 I-III	<u>2022 I-III</u> <u>2021 I-III</u>
	сая төгрөг		хувь
<b>Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого</b>	<b>93 325.9</b>	<b>151 011.9</b>	<b>161.8</b>
Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн шимтгэл	4 462.7	7 893.5	176.9
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	3 279.0	6 162.6	187.9
Малчин	909.7	1 300.0	142.9
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	274.0	430.9	157.3
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	74 776.8	102 191.9	136.7
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	14 086.4	40 926.5	2.9 <sup>1</sup>
<b>Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө<sup>1*</sup></b>	<b>124 116.3</b>	<b>135 106.0</b>	<b>108.9</b>
<b>Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал</b>	<b>187 420.5</b>	<b>617 936.1</b>	<b>3.3<sup>1</sup></b>
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	175 412.4	584 506.8	3.3 <sup>1</sup>
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	808.3	7 540.0	9.3 <sup>1</sup>
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	11 199.8	25 889.3	2.3 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин их

Тайлбар: <sup>1\*</sup>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр тогтоол

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нэмэгдэхэд төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл 40.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.8 (2.9 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын хэмжээнд 2022 оны 3 дугаар сард эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 3.2 сая хүн даатгуулсан нь өмнөх оны мөн үеэс 129.8 мянга (4.3%)-аар нэмэгджээ.

Энэхүү өсөлтөд шимтгэлийг нь ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд 39.5 мянга (5.3%)-аар, шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд өмнөх оноос 38.9 мянга (1.8%)-аар, нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 III	2022 III	<u>2022 III</u> 2021 III
	хүн		хувь
<b>Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид</b>	<b>3 020 659</b>	<b>3 150 479</b>	<b>104.3</b>
<b>Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд</b>	<b>744 846</b>	<b>784 354</b>	<b>105.3</b>
Төсөвт байгууллагын ажилтан	240 944	244 444	101.5
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	503 902	539 910	107.1
<b>Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд</b>	<b>80 159</b>	<b>131 539</b>	<b>164.1</b>
Малчин	19 873	25 568	128.7
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	54 536	98 686	181.0
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	5 661	7 185	126.9
Бусад даатгуулагч	89	100	112.4
<b>Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд</b>	<b>2 195 654</b>	<b>2 234 586</b>	<b>101.8</b>

Тайлбар: Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид давхардсан тоогоор орсон болно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Улсын хэмжээнд 2022 оны 3 дугаар сард эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлж, хамгийн их жор бичигдсэн 5 эмийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад халдварын эсрэг бэлдмэлийн эм 60.8 (11.2%) сая төгрөг, сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм 92.6 (18.8%) сая төгрөг, зүрх судасны эмийн борлуулалт 869.4 (32.0%) сая төгрөг, ходоод гэдэсний замын өвчнийг эмчлэх эм 394.1 (41.4%) сая төгрөг, даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл 199.7 (43.3%) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЖ, ЖОР БИЧИГДСЭН ЭМ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, эмийн ерөнхий бүлгээр

Үзүүлэлт	2021 III	2022 III	<u>2022 III</u> 2021 III
	сая төгрөг		хувь
<b>Дүн</b>	<b>5 939.0</b>	<b>7 729.1</b>	<b>130.1</b>
Зүрх судасны эм	2 719.5	3 588.9	132.0
Халдварын эсрэг бэлдмэл	543.5	604.3	111.2
Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм	951.1	1 345.2	141.4
Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм	493.8	586.4	118.8
Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл	461.4	661.1	143.3
Бусад эм	769.7	943.2	122.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

## Ойлголт, тодорхойлолт

**Эрүүл мэндийн даатгал:** Төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.

**Даатгуулагч:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ.

**Бусад даатгуулагч:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.9-т зааснаас бусад даатгуулагчид орно.

**Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэд:** 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж буй ялтныг хамруулж ойлгоно.

**Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн:** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-т заасан тэтгэвэр авагчид, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т заасан иргэдийг хэлнэ.

**Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн**

**гишүүн-иргэн:** Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 -д заасан ҮСХ, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



## Эх үүсвэр:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сарын мэдээ

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 7 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн  
газрын дарга А.Амарбал  
Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын  
Нийгмийн статистикийн хэлтсийн статистикч  
Э.Ариунчимэг  
Утас : (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212